



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Залруулга.....	Error! Bookmark not defined.
5.2 Зөвлөмж	15
5.3 Албан шаардлага.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠘᠗᠔.᠒᠗.᠒᠑ № 1᠒᠘

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН АРВАН НЭГДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.ЭНХСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын арван нэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Төсвөөс 490,444.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 455,264.6 мянган төгрөг зарцуулж, 35,180.3 мянган төгрөгийг хэмнэлттэй ажилласан байна. Үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 114,539.7 сая төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,711,789.00	78,901,677.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	32,947,357.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	32,947,357.87
3121	Төгрөг	-	32,947,357.87
31211	Төрийн сангийн харилцах	-	32,947,357.87
33	АВЛАГА	-	1,767,078.33
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	1,767,078.33
35	БАРАА МАТЕРИАЛ	31,711,789.00	44,187,241.60
354	Хангамжийн материал	31,711,789.00	44,187,241.60
35460	Хүнсний материал	1,306,189.00	75,041.60
35470	Бусад хангамжийн материал	30,405,600.00	44,112,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	716,929,534.25	649,552,199.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	716,929,534.25	649,552,199.34
392	Биет хөрөнгө	675,403,201.03	606,967,866.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	711,047,486.80	711,047,486.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,322,429.40)	(123,440,751.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,380,657.00	36,505,657.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,845,920.72)	(24,795,580.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,711,662.00	42,011,662.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,538,254.89)	(34,845,593.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,425,000.00	2,425,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,454,999.76)	(1,940,013.84)
393	Биет бус хөрөнгө	41,526,333.22	42,584,333.18
39301	Програм хангамж	1,210,000.00	2,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(927,666.78)	(1,369,666.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,244,000.00	41,244,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	748,641,323.25	728,453,877.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	348,940.00	5,341,598.33
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	348,940.00	5,341,598.33
413	Өглөг	348,940.00	5,341,598.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,767,078.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	589,500.00
4136	Бусад өглөг	348,940.00	2,985,020.00
41361	Байгууллагад төлөх өглөг	348,940.00	2,985,020.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	748,292,383.25	723,112,278.81
51	Засгийн газрын хувь оролцоо	748,292,383.25	723,112,278.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,244,000.00	41,244,000.00
51101	Өмч: - төрийн	41,244,000.00	41,244,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	707,048,383.25	681,868,278.81
51210	Өмнөх үеийн үр дүн	707,048,383.25	(41,592,940.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	723,461,218.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	748,641,323.25	728,453,877.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	380,866,600.00	1,257,313,864.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,344,400.00	766,868,923.25
120	Нийтлэг татварын бус орлого	480,000.00	766,868,923.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	480,000.00	766,868,923.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	480,000.00	766,868,923.25
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	308,864,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	308,864,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,522,200.00	490,444,941.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	393,383,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	393,383,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,708,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,708,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,814,200.00	97,061,941.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,814,200.00	97,061,941.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	421,080,001.09	533,852,645.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,080,001.09	533,852,645.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,471,558.75	533,852,645.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,201,010.12	276,496,510.54
210101	Үндсэн цалин	165,086,467.12	203,490,081.59
210102	Нэмэгдэл	58,230,023.28	60,111,488.46
210104	Урамшуулал	21,884,519.72	12,894,940.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,506,394.54	38,428,854.44
210201	Тэтгэврийн даатгал	22,030,882.52	26,336,017.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,394,670.35	3,316,195.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,915,596.12	2,344,696.22
210204	Ажилгүйдлийн даатгал	681,301.84	596,797.26
210205	Эрүүл мэндийн даатгал	4,483,943.71	5,835,148.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,470,872.09	68,876,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,579,551.09	4,193,969.83
210302	Түлш, халаалт	54,398,281.00	57,923,280.00
210303	Цэвэр, бохир ус	4,493,040.00	6,759,350.17
2104	Хангамж, бараа материалын зардал	10,379,113.00	-
210401	Бичиг хэрэг	4,590,097.00	-
210402	Тээвэр, шатахуун	375,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	284,000.00	-
210404	Ном, хэвлэл	479,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,650,116.00	-
2105	Нормативт зардал	27,049,461.52	52,727,765.91
210502	Хоол, хүнс	22,724,203.00	52,727,765.91
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,173,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,230,918.00	5,204,830.00
210604	Урсгал засвар	3,230,918.00	5,204,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,609,500.00	652,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,609,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	652,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,024,289.48	91,465,584.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,500.00	8,031,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,349,200.00	4,131,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,579,589.48	79,302,334.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,608,442.34	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,408,442.34	-

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,408,442.34	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(40,213,401.09)	723,461,218.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(40,213,401.09)	723,461,218.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	380,386,600.00	490,444,941.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,864,400.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	308,864,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	308,864,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,522,200.00	490,444,941.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	393,383,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	393,383,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,708,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,548,000.00	-
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,814,200.00	97,061,941.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,814,200.00	97,061,941.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	380,386,600.00	453,497,583.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,386,600.00	453,497,583.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,778,157.66	453,497,583.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,209,999.21	277,229,146.56
210101	Үндсэн цалин	171,733,556.96	203,207,515.94
210102	Нэмэгдэл	44,048,670.74	60,111,488.47
210104	Урамшуулал	18,427,771.51	13,910,142.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,830,021.84	37,696,218.42
210201	Тэтгэврийн даатгал	22,681,849.25	25,554,700.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,302,659.82	2,931,392.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,847.72	2,341,894.24
210204	Ажилгүйдлийн даатгал	694,159.42	585,398.59
210205	Эрүүл мэндийн даатгал	4,309,505.63	6,282,832.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,220,672.09	68,876,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,579,551.09	4,193,969.83
210302	Түлш, халаалт	53,251,501.00	57,923,280.00
210303	Цэвэр, бохир ус	5,389,620.00	6,759,350.17
2104	Хангамж, бараа материалын зардал	10,391,396.00	-
210401	Бичиг хэрэг	2,405,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	375,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	284,000.00	-
210404	Ном, хэвлэл	479,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,847,496.00	-
2105	Нормативт зардал	26,862,140.52	50,907,118.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,053,558.52	-
210502	Хоол, хүнс	23,634,882.00	50,907,118.51
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,173,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,778.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,499,778.00	5,000,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,569,200.00	652,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,569,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	652,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,194,950.00	13,136,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	9,146,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,301,950.00	3,990,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,608,442.34	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,408,442.34	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,408,442.34	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	36,947,357.87
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	32,947,357.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,244,000.00	707,048,383.25	748,292,383.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,244,000.00	707,048,383.25	748,292,383.25
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,244,000.00	707,048,383.25	748,292,383.25
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,244,000.00	707,048,383.25	748,292,383.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-748,641,323.25	-748,641,323.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,244,000.00	-41,592,940.00	-348,940.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	723,461,218.81	723,461,218.81
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,244,000.00	681,868,278.81	723,112,278.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	496,557,800.00	457,497,583.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	496,557,800.00	457,497,583.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,557,800.00	457,497,583.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,191,700.00	277,229,146.56
210101	Үндсэн цалин	238,075,200.00	203,207,515.94
210102	Нэмэгдэл	61,887,600.00	60,111,488.47
210104	Урамшуулал	6,228,900.00	13,910,142.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,899,400.00	37,696,218.42
210201	Тэтгэврийн даатгал	27,155,600.00	25,554,700.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,185,800.00	2,931,392.78

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,548,800.00	2,341,894.24
210204	Ажилгүйдлийн даатгал	637,300.00	585,398.59
210205	Эрүүл мэндийн даатгал	6,371,900.00	6,282,832.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,876,600.00	68,876,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,193,969.83
210302	Түлш, халаалт	57,952,100.00	57,923,280.00
210303	Цэвэр, бохир ус	5,924,500.00	6,759,350.17
2105	Нормативт зардал	52,936,600.00	50,907,118.51
210502	Хоол, хүнс	52,936,600.00	50,907,118.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,109,000.00	652,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,109,000.00	652,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,544,500.00	17,136,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,554,500.00	13,146,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,990,000.00	3,990,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	491,987,300.00	490,444,941.36
122005	Орон нутгийн төсвөөс	491,987,300.00	490,444,941.36
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,947,357.87

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баруун урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасны дагуу бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох, хэл яриа, сэтгэхүй чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох, хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах, хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах юм.

Баруун урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун-Урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруун-Урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,187.4 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	32,947.3	(32,947.3)
Авлага	-	1,767.1	(1,767.1)
Бараа материал	31,711.7	44,187.2	12,475.4
Үндсэн хөрөнгө	716,929.5	649,552.1	(67,377.3)
Нийт хөрөнгө	748,641.3	728,453.8	20,187.4
Өр төлбөр	348.9	5,341.5	4,992.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	748,292.3	723,112.2	(25,180.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	748,641.3	728,453.8	20,187.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 32,947.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэл нь 2021 оноос 1,767.1 мянган төгрөгөөр буюу 100 хувиар өссөн нь ажилчидтай холбогдсон авлагууд үүссэн байна.

Бараа материалын үлдэгдэл 44,187.2 мянган төгрөг болж 12,475.4 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 649,552.1 мянган төгрөг болж, 67,377.3 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар буурчээ.

Өр төлбөрийн үлдэгдэл нь 5,341.5 мянган төгрөг болж өссөн нь аж ахуйн материалын зардал, ажилчидтай холбоотой өр төлбөр төлөгдөөгүй улмаас 93.5 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 876,447.2 мянган төгрөг буюу 69.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. 766,868.9 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилга үнэ төлбөргүй орлого хүлээн авснаас гол шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 112,772.6 мянган төгрөг буюу 21.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хоол хүнс, гэрэл цахилгаантай холбоотой зардал байна. Цалингийн зардал 38,403.6, түлш халаалт 3,524.9, цэвэр, бохир ус 2,266.3, хоол, хүнс 30,003.5 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд багш, сурган хүмүүжүүлэгчийн тоог нэмэгдүүлж, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжихийг эрхэмлэж чанартай хоол хүнс, дулаан орчин бүрдүүлж, үйл ажиллагааны хүрээ өргөжсөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 715,095.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 715,095.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 216,537.8 мянган төгрөгөөр бууруулж, 336,799.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 496,557.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэл 457,497.5 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,100.0	1,100.0	-	100%
2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	52,936.6	50,907.1	2,029.5	96.1%
3	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,504.5	1,504.5	-	100%
4	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээш	1,100.0	1,100.0	-	100%
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	273,341.1	250,535.8	22,805.3	91.6%
6	83602-ЗГ болон ЗД-ийн нөөц хөрөнгөөс хувиарилсан	4,570.0	4,000.0	570.0	87.53%
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	58,830.8	51,288.2	7,542.6	87.1%
8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	73,876.6	73,876.6	-	100%
9	80112-Нийтлэг үйлчилгээ	24,003.2	23,185.3	817.8	96.5%
НИЙТ		496,557.8	457,497.5	39,060.3	92.1%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 92.1 хувьтай хэрэгжсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах Д.Сарнай нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун-Урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 6,315.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,736.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд газрын төлбөрөөс өөр хэтэрсэн зардал байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баруун урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэг нь 2022 онд нийт 496,557.8 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” Гэж заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

1. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт/Бүтэн жилээр оруулах мэдээлэл/
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө/Бүтэн жилээр оруулах мэдээлэл/
3. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн/Тухай бүрд оруулах мэдээлэл/
4. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт/Улирал бүр оруулах мэдээлэл/

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баруун урт сумын Арваннэгдүгээр цэцэрлэгт завсрын аудит хийгээгүй.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 349,713.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 349,713.0 мянган төгрөгийн залруулга хийж 100 хувьтай биелсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1,705.8	3	1,705.8	100%
Албан шаардлага	1	566.6	1	566.6	100%
Зөвлөмж	2	347,440.6	2	347,440.6	100%
Нийт дүн	6	349,713.0	6	349,713.0	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,511.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,767.0 мянган төгрөгийн залруулга, 24,744.7 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Залруулга

1. Ажилчдын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцохгүй цалин бодсоноос 1,767.0 мянган төгрөгийг илүү суутгасныг засуулав.

5.2 Зөвлөмж

1. Шилэн данстай холбоотой асуудал

1 Илрүүлэлт: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2022 онд нийт 496,557.8 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлээгүй байна.

2. Өгсөн зөвлөмж

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах.

5.3 Албан шаардлага

Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аж ажуй нэгж байгууллагатай холбоотой 24,744.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтыг бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Төлбөрийн акт		Үүнээс				Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцохгүй цалин бодсон	1	1,767.0			1	1,767.0			-	-
Дүн	1	1,767.0	-	-	1	1,767.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	1	-	-	-	-	-	-	1	-
ААН холбоотой зардал татварын цахим системд бүртгэгдээгүй.	1	24,744.7	-	-	1	24,744.7	-	-	
Дүн	2	24,744.7	-	-	1	24,744.7	1	-	